

Боржигин чуулгын даргын 2019 оны
09 сарын 12 ны өдрийн
А/55 тоот тушаалын 4-р хавсралт

ХӨГЖМИЙН ЗЭМСЭГ ТҮРЭЭСЛЭХ ЖУРАМ

НЭГ. ЗОРИЛГО

Мэргэжлийн урлагийн байгууллага нь өөрийн орлогыг бүрдүүлэх, Аж ахуйн нэгж, албан байгууллага, иргэдэд соёл урлагийн үйл ажиллагаа, арга хэмжээнд нь дэмжлэг үзүүлэхэд оршино.

ХОЁР. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Чуулгын дансанд бүртгэлтэй нийт хөгжмийн зэмсэгүүдийг Нумт, Цохиур, Үлээвэр, Даралтат хөгжим гэж 4 ангилна.

1. Нумт хөгжим- Морин хуур, Их хуур
2. Цохиур хөгжим- Ёочин, Ятга, Литавар, Шанз, Хэнгэрэг, Бөмбөр
3. Үлээвэр хөгжим- Лимбэ, Эвэр бүрээ, Бишгүүр, Цордон, Гобай, Кларнет, Саксфон, Торонбой
4. Даралтат хөгжим- Төгөлдөр хуур, YAMAHA

ГУРАВ. ТҮРЭЭСЛЭГЧИЙН ҮҮРЭГ

3.1 Түрээслэгч нь хөгжмийн зэмсгийн тоо ширхэг, хугацаа заасан хүсэлт /тусгай хүснэгт бүхий хуудас/-ыг гарган чуулгын хөгжмийн удирдаачаар дамжуулан байгууллагын даргын зөвшөөрөл авна.

3.2 Түрээслэгч зөвшөөрөгдсөн тохиолдолд тарифын дагуу үнийн дүнг 100% бэлнээр буюу байгууллагын дансанд байршуулснаар хөгжмийн зэмсгийг авна.

3.3 Түрээслэгч нь түрээслэсэн хөгжмийн зэмсгийг анх авсан бүрэн бүтэн байдлыг алдагдуулахгүй, хугацааг хатуу баримтлан алдах, эвдэж хэмхэлсэн, гэмтэл учруулсан тохиолдолд анх худалдан авсан үнийн дүнгээр төлнө.

ДӨРӨВ. ТҮРЭЭСЛҮҮЛЭГЧИЙН ҮҮРЭГ

4.1 Түрээслэгч талын хүсэлтийн дагуу зохих зөвшөөрлийг олгоно.

4.2 Түрээсээр өгөх зүйлийн бүрэн бүтэн байдлын талаар тусгай тэмдэглэл хөтлөн гарын үсгээр баталгаажуулж олгоно.

4.3 Түрээсийн төлбөрийг бүрэн хэмжээгээр авах, эвдэх, алдагдсан тохиолдолд захиргаанд мэдэгдэн төлбөрийг түрээслэгч талаас гаргуулах

ХӨГЖМИЙН ЗЭМСЭГ ТҮРЭЭСЛЭХ ҮНЭ ТАРИФ

№	Ангилал	Тоо ширхэг	Үнэ	Нэмэлт тайлбар
1	Нумт хөгжим	1	60000	Морин хуур Их хуур
2	Цохиур хөгжим	1	80000	Ёочин, Ятга, Литавар, Шанз, Хэнгэрэг, Бөмбөр
3	Үлээвэр хөгжим	1	70000	Лимбэ, Эвэр бүрээ, Бишгүүр, Цордон, Гобэй, Кларнет, Саксфон, Торонбой
4	Даралтат хөгжим	1	50000	Yamaha